



Asian Development Bank

**TA 6618-REG ENABLING A CONDUCTIVE
ENVIRONMENT FOR THE DIGITAL ECONOMY**

**МОНГОЛ УЛСАД ЦАХИМ ХУДАЛДААНЫ ТААТАЙ
ОРЧИНГ БҮРДҮҮЛЭХ НЬ**

**OUTPUT 1: Legal and regulatory barriers to
effective and efficient e-commerce identified and
recommendations for improvement developed.**

Төслийн үндэсний зөвлөх, хуульч А.Дэлгэрмаа

Монгол улс дахь Цахим худалдаатай холбоотой хууль, эрх зүйн орчин

- Монгол Улсын хэмжээнд 2023 оны 1 дүгээр сарын байдлаар цахим арилжаа болон худалдааны асуудлыг зохицуулсан бие даасан хууль байхгүй байна. “Цахим худалдаа” гэсэн үгэн хайлтаар цөөн тооны хуульд зарим нэг зүйл, заалт тусгагдсан байна.
- Ерөнхийдөө худалдааны салбар өөрөө том салбар учраас худалдааны асуудлыг зохицуулсан бие даасан хууль байхгүй ч олон тооны салбарын хуулиудын зохицуулалт худалдааны асуудалд хамаарч байдаг.

Цахим худалдаанд хамаарах хууль тогтоомжууд:

- Иргэний хууль (2002)
- Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих тухай хууль (2019)
- Үндэсний төлбөрийн системийн тухай хууль (2017)
- Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хууль (2019)
- ИХШХШТХУУЛЬ (2002)
- Шуудангийн тухай хууль (2003)
- Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль (2003)
- Цахим гарын үсгийн тухай хууль (2021)
- Хүний хувийн мэдээлэл хамгаалах хууль тухай хууль (2021)
- Кибер аюулгүй байдлын хууль (2021)
- Эрүүгийн хууль (2015)
- Гааль, татварын хууль тогтоомжууд

Иргэний хууль (2002)

42¹ дугаар зүйл. Цахим хэлбэрээр хийх хэлцэл

42¹.1. Хуульд зааснаар бүртгүүлэх, нотариатаар гэрчлүүлбэл зохих болон бичгээр хийхээр заасан хэлцлийг цахим хэлбэрээр хийж болно.

42¹.2.Хуульд өөрөөр заагаагүй бол цахим хэлбэрээр хийх хэлцэл нь талууд хүсэл зоригоо харилцан илэрхийлж, цахим баримт бичиг үйлдэж, тоон гарын үсэг зурснаар, эсхүл бусад байдлаар техникийн хэрэгсэл, программ хангамжийг ашиглан хүсэл зоригоо илэрхийлж, харилцан хүлээн зөвшөөрч, цахим гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

43 дугаар зүйл. Хэлцэл хийсэн гэж үзэх

43.2.Бичгээр хийх хэлцлийг дараахь тохиолдолд хийсэн гэж үзнэ:

43.2.4.цахим хэлбэрээр хэлцэл хийх бол талууд хүсэл зоригоо илэрхийлсэн цахим баримт бичиг үйлдэж, Цахим гарын үсгийн тухай хуульд заасан цахим гарын үсэг зурсан.

196 дугаар зүйл. Гэрээг байгуулсанд тооцох

196.1.8.цахим хэлбэрээр гэрээ хийх бол талууд хүсэл зоригоо харилцан илэрхийлж цахим баримт бичиг үйлдэж, тоон гарын үсэг зурснаар, эсхүл бусад байдлаар техникийн хэрэгсэл, программ хангамжийг ашиглан хүсэл зоригоо илэрхийлснийг харилцан хүлээн зөвшөөрч цахим гарын үсэг зурснаар.

Цахим гарын үсгийн тухай хуультай холбогдуулан 2021 онд өөрчлөн найруулсан.

Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих тухай хууль (2019)

17 дугаар зүйл.Жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх

17.1.Жижиг, дунд үйлдвэрийн талаарх төрийн бодлогыг хэрэгжүүлэх чиг үүргийг жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага эрхлэн дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
17.1.12.цахим худалдаа нэвтрүүлэх, зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;

Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хууль (2019)

12 дугаар зүйл.Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хяналт

12.2.Хяналт хэрэгжүүлэх эрхтэй этгээд иргэн, хуулийн этгээдээс дараах хэлбэрээр ирүүлсэн мэдээлэл, өргөдөл, гомдлын дагуу хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээг авна:

12.2.1.цахим хуудас;

12.2.2.цахим худалдаа, нийгмийн сүлжээнд байршуулсан нотолгоо бүхий мэдээлэл;

ИХШХШТХУУЛЬ (2002)

37.2.Хэргийн нотлох баримт нь зохигч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгчийн тайлбар, гэрчийн мэдүүлэг, бичмэл ба цахим баримт, эд мөрийн баримт, эсхүл баримт бичиг, шинжээчийн дүгнэлт, кино ба гэрэл зураг, зураглал, дүрс, дууны бичлэг, ул мөрнөөс буулгаж авсан хэв, үзлэг, туршилт, таньж олуулах ажиллагааны болон шүүх хуралдааны тэмдэглэл зэрэг нотолгооны хэрэгслээр тогтоогдоно .

Худалдаа болон арилжааны хууль тогтоомжийн зарим асуудал

- Худалдааны эрх зүйн орчин: Монгол Улсын хувьд нийт 800 гаруй бие даасан хууль хүчин төгөлдөр үйлчилж буй бөгөөд үүнээс хувийн эрх зүйн худалдааны харилцаанд хамаарах 60 орчим хууль байна. Өнөөгийн байдлаар худалдааны харилцааг олон салбарын хуулиар хэсэгчлэн зохицуулж байна. Тухайлбал, Иргэний хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Гаалийн тухай хууль, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль, Зарим бараанд экспортын гаалийн татварын хэмжээ тогтоох тухай хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, Онцгой албан татварын тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Патентын тухай хууль, Хүнсний тухай хууль, Хүнсний аюулгүй байдлыг хангах тухай хууль зэрэг бусад салбарын хууль тогтоомжид худалдаатай холбоотой зохицуулалтууд туссан байдаг боловч худалдааны харилцааг зохицуулах нэгдсэн бодлого, худалдааны бие даасан хууль өнөөг хүртэл байхгүй байна.
- Худалдааны хуулийн төсөл: 2001 оноос Худалдааны хуулийн төслийн Гадаад худалдааны хууль гэх мэт хэд хэдэн хувилбар боловсруулах ажил явагдсан бөгөөд Засгийн газарт ч нэлээдгүй удаа хэлэлцүүлж, УИХ-д мөн өргөн барьж байсан. Хуулийн төсөл олон жил боловсруулагдаж буй боловч батлагдаагүй нэг шалтгаан нь институцийн тогтворгүй, тодорхойгүй байдал юм. захирамжаар Худалдааны тухай хуулийн төслийг боловсруулж, МУИХ-ын даргын 2021 оны 45 дугаар захирамжаар Худалдааны тухай хуулийн төслийг боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлэх үүрэг бүхий ажлын хэсэг УИХ дээр мөн байгуулагдсан байдаг. Одоогоор худалдааны нэгдсэн бодлогыг ЭЗХЯ, гадаад худалдааны асуудлыг ГХЯ хариуцаж байна. Хууль тогтоомжийг боловсронгуй болгох Үндсэн чиглэл дээр “Гадаад худалдааны тухай хууль”-ийн төслийг ГХЯ-аас хариуцаж боловсруулахаар тусгасан байсан. Цаашид Худалдааны хуулийн асуудлыг нэгмөр шийдвэрлэж, зохицуулах нь зүйтэй.
- Арилжааны хуулийн асуудал: Монгол Улсын хувийн эрх зүйн салбарын үндсэн хууль бол Иргэний хууль бөгөөд тус хуульд арилжааны асуудлыг зохицуулсан байдаг. Бусад улс орнууд хэмжээнд арилжааны /commercial/ асуудлыг зохицуулсан бие даасан хуультай байдаг бөгөөд тус хуулиар хувь болон хуулийн этгээдийн хооронд эдийн засаг, бизнес, арилжааны олон талт харилцааг зохицуулдаг давуу талтай байна. Манай улсын хувьд Хууль зүй, дотоод хэргийн яам, МУИС-ийн ХЗС хамтран Арилжааны хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийг байгуулж, суурь судалгааны ажлыг 2016 оноос эхлүүлсэн бөгөөд одоогоор хуулийн төслийн үзэл баримтлалыг хэлэлцэх шатанд явж байна.

Цахим худалдааны шинэ хууль, эрх зүйн орчин

- Цахим худалдааны шинэ хуулийн төсөл боловсруулах асуудал – анхдагч хуулийн төсөлд тооцогдоно.
- ЮНСИТРАЛ “Цахим худалдааны тухай загвар хууль”-д тулгуурлах, олон улсын харьцуулсан судалгаа, шилдэг туршлагыг харгалзах
- Цахим худалдааг зохицуулах асуудлыг - Худалдааны тухай хуулийн нэг бүлгээр зохицуулах
- Арилжааны хуулийн төсөл – цахим худалдааны зохицуулалт
- Холбогдох бусад хууль тогтоомж дахь зохицуулалтуудыг уялдуулах, Татварын хууль тогтоомж, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах хууль, Эрүүгийн хууль, Хаягжуулалтын хууль
- Засгийн газрын түвшинд хуулийн асуудлаар холбогдох яамд, ажлын хэсгүүд нь хамтарсан уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах, асуудлыг хэлэлцэх, шийдвэрлэх
- Хууль тогтоомжийн тухай хуулийн шаардлагыг хангах, холбогдох судалгааг хийх, ажлын хэсгийг олон талт оролцогчдоор бүрдүүлэх, хэлэлцүүлэг зохион байгуулах

Цахим худалдаатай холбоотой нэр томъёоны асуудал

- Цахим худалдаа болон цахим харилцаа холбооны салбарт их олон гадаад нэр томъёо хэрэглэгдэж буй бөгөөд эдгээрийг монголоор орчуулах, тогтсон нэр томъёог зөв хэрэглэх, ойголтын хувьд зөрүүгүй байх, хууль, эрх зүйн зохицуулалт талаас нь Монгол хэлний тухай хууль, Хууль тогтоомжийн тухай хуулийн шаардлагад нийцүүлэн анхаарах шаардлагатай.
- Жишээлбэл, electronic, digital, e-commerce, e-trade, platform, application, cyber security, digital signature, electronic signature, online. Mobile app, QR code гэх мэт
- e-commerce гэдэг үг монголоор бол цахим худалдаа гэж буюугаад хэрэглэгдээд байна, өөрөөр хэлбэл худалдаа гэдгээр түлхүү ойлгож ирсэн. e-trade гэж бас монголоор цахим худалдаа. Commerce гэдэг үг нь нэг талаас худалдаа, нөгөө талаас арилжаа гэж орчуулагдана. Жишээ нь commercial law гэдэг нь арилжааны хууль гэж орчуулагдана, digital signature, electronic signature нь аль аль нь цахим гарын үсэг гэж орчуулагдах гэх мэт.